



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 02 өдөр

Дугаар А/236

Хэрлэн сум

Хүүхэд хамгааллын явуулын  
үйлчилгээний зардалд хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн хүүхдийн төлөө зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 9 дэх заалтын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээний зардалд 7,000,000 (долоон сая) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Дээрх арга хэмжээний зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүүхдэд ээлтэй орон нутаг зардлаас олгохыг аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, гүйцэтгэлийг үр дүнтэй зохион байгуулж, тайлагнахыг Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын дарга (Х.Уртнасан)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Н.Зоригтбаатар)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2024 оны  
05 дугаар сарын 02-ны өдрийн  
236 дугаар захирамжийн хавсралт

### ХӨРӨНГӨ ЗАРЦУУЛАЛТЫН ТООЦОО

№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ ₮
1	Бензин	492.06 Литр	2520	1.240.000
2	Томилолт	10 хоног/ 6 хүн	90.000	5.400.000
		2 хоног/2 хүн	90.000	360.000
	Нийт зардал			7.000.000